

ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 12 дугаар сарын 18

№02

Улаанбаатар хот

Хөтөлбөрийн ерөнхий хорооны хурал 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр 10:00 цагаас 85,7 хувийн ирцтэй эхэлж, ХЕХ-ны дарга Н.Эрдэнэхүү удирдан явуулав.

Хуралд:

Хөтөлбөрийн ерөнхий хорооны дарга

1. Н.Эрдэнэхүү Сургалт, оюутны асуудал эрхэлсэн проректор

Нарийн бичгийн дарга

2. М.Эрдэнэтуяа Сургалтын бодлого, зохицуулалтын албаны дарга

Гишүүд

- | | |
|------------------|---|
| 3. И.Цэрэн-Онолт | АТС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгч |
| 4. Б.Майзул | ХХҮДС-ийн биотехнологи, шим судлалын тэнхимийн профессор |
| 5. Ц.Цэцэгмаа | ГХС-ийн хэрэглээний хэл шинжлэлийн тэнхимийн профессор |
| 6. Д.Ариунболор | НБХ-ийн профессор |
| 7. Ц.Балжинням | ХШУС-ийн сургалт, чанарын албаны дарга |
| 8. П.Ууганбаяр | МХТС-ийн сургалт, чанарын албаны дарга |
| 9. Н.Одонтуяа | ДаТС-ийн сургалт, чанарын албаны дарга |
| 10. Ш.Цоож | МИТС-ийн механик инженерчлэлийн тэнхимийн дэд профессор |
| 11. Я.Наранцэцэг | АТС-ийн профессор |
| 12. Ц.Энхбаатар | ГХС-ийн захирал |
| 13. Ч.Алдармаа | ХШУС-ийн физикийн тэнхимийн профессор (ӨмТДС-ийн төлөөлөл, зөвшилцсөнөөр) |
| 14. Д.Үлэмж | ЭХИС-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга |
| 15. С.Туяа | НХС-ийн сургалт, чанарын албаны дарга |
| 16. Ж.Алтанцэцэг | БАС-ийн барилгын инженерчлэлийн тэнхимийн дэд профессор |
| 17. М.Банзрагч | МС-ийн сургалт, чанарын албаны дарга |
| 18. Г.Ариунтөгс | Сургалтын бодлого, зохицуулалтын албаны ахлах мэргэжилтэн |

нар оролцов.


Хэлэлцэх асуудлууд:

1. "101301. Зочлох үйлчилгээ" бакалаврын хөтөлбөр нээх тухай (НХС)
 - ХДХ-ны ахлагч С.Туяа
2. 054102. Хэрэглээний математик" бакалаврын хөтөлбөр нээх тухай (ХШУС)
 - ХДХ-ны ахлагч Ц.Балжинням
3. "061902. Хиймэл оюун" магистрын хөтөлбөр нээх тухай (МХТС)
 - ХДХ-ны ахлагч П.Ууганбаяр
4. "061202. Кибер аюулгүй байдал" докторын хөтөлбөр нээх тухай (МХТС)
 - ХДХ-ны ахлагч П.Ууганбаяр
5. Сургалтын хөтөлбөрийн боловсролын зэргийг тодорхойлох
 - СОАЭ проректор Н.Эрдэнэхүү
6. Бусад асуудал

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. НХС-д Зочлох үйлчилгээ(101301) бакалаврын хөтөлбөр нээх тухай асуудлыг томилогдсон шинжээч, хөтөлбөрийн ерөнхий хорооны гишүүдийн зөвлөмжийн дагуу зарим бүрэлдэхүүн хэсэгт сайжруулалтыг хийн урьдчилсан магадлан итгэмжлэл хийлгэхээр БМИҮЗ-д хүсэлт хүргүүлэхийг гишүүдийн 94,4 хувийн саналаар дэмжлээ.
2. ХШУС-д Хэрэглээний математик(054102) бакалаврын хөтөлбөр нээх тухай асуудлыг томилогдсон шинжээч, хөтөлбөрийн ерөнхий хорооны гишүүдийн зөвлөмжийн дагуу зарим бүрэлдэхүүн хэсэгт сайжруулалтыг хийн урьдчилсан магадлан итгэмжлэл хийлгэхээр БМИҮЗ-д хүсэлт хүргүүлэхийг гишүүдийн 94,4 хувийн саналаар дэмжлээ.
3. МХТС-д Хиймэл оюун(061902) магистрын хөтөлбөр нээх тухай асуудлыг томилогдсон шинжээч, хөтөлбөрийн ерөнхий хорооны гишүүдийн зөвлөмжийн дагуу зарим бүрэлдэхүүн хэсэгт сайжруулалтыг хийн урьдчилсан магадлан итгэмжлэл хийлгэхээр БМИҮЗ-д хүсэлт хүргүүлэхийг гишүүдийн 100 хувийн саналаар дэмжлээ.
4. МХТС-д Кибер аюулгүй байдал(061202) докторын хөтөлбөр нээх тухай асуудлыг хөтөлбөр хариуцсан тэнхимийн эрхлэгч, профессорыг байлцуулан хэлэлцэх шаардлагатай тул дараагийн хөтөлбөрийн ерөнхий хорооны хурлаар хэлэлцүүлэхээр буцаалаа.
5. Сургалт эрхэлсэн захиргааны нэгжээс сургалтын хөтөлбөрийн боловсролын зэргийг тодорхойлох асуудлыг хэлэлцүүлэн дараах байдлаар шийдвэрлэв.
 - Бүрэлдэхүүн сургуулиас ирүүлсэн бакалаврын хөтөлбөрөөр төгсөгчид олгох боловсролын зэргийн саналыг захиргааны нэгж олон улсын шаардлагад нийцүүлэн дахин хянаж, тодорхой санал гарган хөтөлбөрийн ерөнхий хорооны гишүүд, хөтөлбөрийн дэд хороодод танилцуулан саналыг тусган хөтөлбөрийн ерөнхий хороонд дахин хэлэлцүүлэх.
 - Сургалтын хөтөлбөрийн нэрийн өөрчлөлтийг Боловсролын сайдын 2025 оны А/287 тоот тушаалын гуравдугаар хавсралтад заасны дагуу өөрчилж, 2025-2026 оны хичээлийн жилээс мөрдөх.

Танилцсан:



Н.Эрдэнэхүү
/ХЕХ-ны дарга/

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:
/ХЕХ-ны нарийн бичгийн дарга/

М.Эрдэнэтуяа